



## “МАТЕРИАЛИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 15

Дугаар 05

Улаанбаатар хот

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 64 дүгээр зүйлийн 64.2, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.2.1, 7 дугаар зүйлийн 7.1.13, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоол, Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Материалимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг **2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10:30 цагт** “Материалимпэкс” ХК-ийн хурлын танхимд танхимаар болон цахим хосолсон хэлбэрээр хуралдахаар товлосугай.
2. “Материалимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
  - 1.1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх, батлах
  - 1.2. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх, батлах
  - 1.3. Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх, батлах
  - 1.4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
  - 1.5. ТУЗ-ийн үйл ажиллагааны төсөв, гишүүдийн урамшууллын хэмжээг батлах
  - 1.6. Хөндлөнгийн аудитын байгууллагын сонгох, батлах
  - 1.7. Компанийн охин компани болох “Материал кредит” ХХК-ийн үйл ажиллагааг сэргээх буюу ББСБ-ын тусгай зөвшөөрлийг дахин авах, журмуудыг шинэчлэн батлах асуудлыг хэлэлцэх, батлах
  - 1.8. Компанийн охин компани болох “Монгол-Импери турс” ХХК-ийн дүрмийг шинэчлэн батлах, гүйцэтгэх захирал томилох
  - 1.9. Ногдол ашгийн талаарх тайлан, мэдээлэл сонсох
  - 1.10. Бусад зүйл зэрэг болно.
2. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр** тогтоосугай.
3. Ээлжит хурлын мэдэгдлийг хавсралт материалын хамт **2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр** Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржид хүргүүлэх, **2023 оны 03 дугаар сарын 20 ба 04 дүгээр сарын 04-ний өдрүүдэд** олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр, компанийн цахим хуудас болон Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар тус тус дамжуулан хувьцаа эзэмшигчдэд болон нийтэд мэдээллэх, брокер дилерийн компаниудад ээлжит хурлын зарыг цахимаар хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Лхагвачулуунд даалгасугай.

4. Хурлын тооллогын комиссын даргаар Н.Түмэндэмбэрэл /РД: ЛЮ91040408/, гишүүдэд П.Сумъяасугар /РД: УХ95073158/, П.Сувдаа /РД: ХВ71080168/ нарыг тус тус томилсугай.
5. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загварыг Хавсралт №01-ээр, хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт №02-оор, саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчийн санал авах хуудасны агуулгыг Хавсралт №03-аар тус тус баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хуралд эрх бүхий хувьцаа эзэмшигч нь биечлэн хурлын танхимд хүрэлцэн ирэх болон цахим хэлбэрээр оролцож болох ба цахим хэлбэрээр оролцох тохиолдолд харъяа брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хурал зохион байгуулах комиссын гишүүдээр дамжуулан хурлын материалтай танилцах, саналын хуудсыг цахим санал хураалтаар тоолж, эх хувийг битүүмжлэлтэйгээр ирүүлэх ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс болон тооллогын комисст тус тус үүрэг болгосугай.
7. Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичиг, хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээлэл, баримт бичгийн бэлэн болгох эцсийн хугацааг 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөр тогтоосугай.
8. Саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10:00 цагаар тогтоосугай.
9. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах, зохион байгуулах комиссын даргаар Б.Зориг, комиссын гишүүдэд ТУЗ-ийн гишүүн П.Баатарцэрэн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Лхагвачулуун нарыг тус тус томилсугай.
10. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 5 хоногийн дотор буюу 2023 оны 03 дугаар сарын 20-ны дотор хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компанид Монголын хөрөнгийн биржийн сайтад бүртгэгдсэн и-мэйл хаягаар хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Лхагвачулуунд үүрэг болгосугай.
11. Хурлын бэлтгэлийг хууль, журмын дагуу сайтар зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ОЮУН